



“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТУГ-ЫН
ЗАХИРАЛ М.БАТТУЛГА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-51-02, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddic.gov.mn,
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2025-09-23 № 02/2201
танай -ны № -т

Хяналт-шинжилгээ, үнэлгээ
хийсэн тайлан, зөвлөмж
хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу “Үндэсний дата төв” УТУГ-ЫН 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийсэн тайлан зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ Ч.ЗОЛБАЯР



1525082669

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
яамны 2025 оны дөрөвдүгээр сарын *13*-ны
өдрийн *10* дугаар албан бичгийн хавсралт



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УЛСЫН ТӨСӨӨВТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

**“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УЛСЫН ТӨСӨӨВТҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго,
үндэслэл, арга зүй**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”, “Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд заасан яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлэх, дүгнэх зорилт, арга хэмжээг тус тус үндэслэн тухайн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, илэрсэн алдаа, дутагдлыг арилгах, цаашид үүсэж болзошгүй аливаа зэрчлөөс урьдчилан сэргийлэхэд гол зорилго оршино.

Тус байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримтлав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 4 зорилт 14 стратеги, 54 арга хэмжээний биелэлтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүнтэй байна.

**Хүснэгт 1. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдийг
үнэлсэн нэгтгэл.**

| Зорилт | Стратеги | Ажил | Хувь |
|---|--|-----------|--------------|
| ЗОРИЛТ 1: БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ, СУУРЬ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ | | <u>28</u> | <u>82,1%</u> |
| Стратеги 1 | Захиргаа, удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх | 9 | 97% |
| Стратеги 2 | Хамтын ажиллагааг хөгжүүлэх | 5 | 80% |
| Стратеги 3 | Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах | 5 | 46% |
| Стратеги 4 | Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах | 9 | 89% |
| ЗОРИЛТ 2. ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГ БАЙРШУУЛАХ, НЭГТГЭХ, ХАДГАЛАХ | | <u>4</u> | <u>75%</u> |
| Стратеги 1. | Төрийн нэгдсэн мэдээллийн сангийн хууль эрх зүйн орчныг шинэчлэх, таатай нөхцөл бүрдүүлэхэд өөрийн байгууллагын зүгээс шаардлагатай судалгаа шинжилгээ хийж, тесэл, санал боловсруулах | 2 | 100% |
| Стратеги 2. | Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах | 2 | 50% |
| ЗОРИЛТ 3. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ | | <u>13</u> | <u>84,6%</u> |
| Стратеги 1 | Систем, сүлжээ болон орчны аюулгүй байдлыг хангах | 6 | 67% |
| Стратеги 2 | Төрийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах | 4 | 100% |
| Стратеги 3 | Хадлагад хариу үйлдэл үзүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын зөвлөгөө өгөх | 3 | 100% |

| ЗОРИЛТ 4. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ | | <u>9</u> | <u>100%</u> |
|---|--|-----------|--------------|
| Стратеги 1 | Төрийн мэдээлэл солилцооны үйлчилгээ үзүүлэх | 3 | 100% |
| Стратеги 2 | Төрийн байгууллагуудад мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлэх | 2 | 100% |
| Стратеги 3 | Төрийн байгууллага болон иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуулийн дагуу мэдээллийн үйлчилгээгээр хангах | 2 | 100% |
| Стратеги 4 | Монголын интернэтийн харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх | 1 | 100% |
| Стратеги 5 | Контентын харилцан холболтын үйлчилгээ үзүүлэх | 1 | 100% |
| | Нийт | 54 | 85,2% |

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 67 арга хэмжээнээс:

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн гүйцэтгэлтэй – 44 арга хэмжээ,
2. Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн гүйцэтгэлтэй – 2 арга хэмжээ
3. Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30%-ийн гүйцэтгэлтэй – 2 арга хэмжээ
4. Үр дүнгүй буюу 0% гүйцэтгэлтэй – 6 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг арифтемик дунджаар тооцож үзэхэд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт **85.2 хувьтай** буюу Цахим хөгжил, инновац харилцаа холбооны сайдын 2024 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчийт болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 4.5.2-т заасны дагуу **“хэвийн”** үнэлгээ хийгдлээ.

Үр дүнтэй хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурдвал:

1. “Үндэсний дата төв” УТҮГ нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO:27001 стандартын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
2. Төвийн систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах, үйл ажиллагаа, үйлчилгээнд ашиглагдаж буй сервер тоног төхөөрөмж, системийн үйлчилгээг тогтмол гүйцэтгэх, ашиглалтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.
3. Байгууллагын хэмжээнд IPv6 технологийг нэвтрүүлж цахим хуудасны хостингийн системийн 8 серверт байрших 1,434 цахим хуудсыг IPv6 хаягт шилжүүлсэн байна.
4. “Үндэсний дата төв” УТҮГ нь дотоод сүлжээний дэд бүтцийг шинэчлэх ажлын төлөвлөгөөг батлуулж гадаад фаерволл дээр 163 дэд сүлжээ шинээр үүсгэсэн байна.

Хэрэгжээгүй болон хэрэгжилт хангалтгүй арга хэмжээнүүдээс дурдвал

1. Захиргаа, удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх зорилтын 1.2.2-т “Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх арга хэмжээ авах”
2. Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах зорилтын 1.3.4-т “Төвийн дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах”
3. Систем сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах зорилтын 1.4.6-д “Төрийн зохиомол серверийн дэд бүтцийг өргөтгөх”
4. Төрийн мэдээллийн санг байршуулах, нэгтгэх, хадгалах зорилтын 2.2.2-т “Мэдээллийн сангудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах”
5. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилтын 3.1.4-т “Төвийн хэмжээнд цахим аюулгүй байдал, эцсийн төхөөрөмжүүдийн хяналтыг сайжруулах”, 3.1.5-т “Орчны аюулгүй байдлыг хангах” арга хэмжээнүүдийн биелэлтийг тайланц тусгаж ирүүлээгүй байна.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг хянаж үзэхэд нийт арга хэмжээний 81% нь бүрэн хэрэгжсэн үр дүнтэй гүйцэтгэлтэй байгаа нь сайшаалтай байна. Үүний зэрэгцээ дараах зөрчлүүд илэрсэн.

Үүнд:

1. "Үндэсний дата төв" УТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн тайланг ирүүлэхдээ 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдөр баталсан 54 арга хэмжээнээс 48 арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан ирүүлсэн.
2. Тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу 2000 тэмдэгтээс хэтэрсэн, шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утyg илэрхийлсэн үр дүн нь тодорхой байдлаар тайлагнаагүй.

Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / зөвлөмж /

Хэрэгжилт хангалтгүй ажлуудыг 2025 онд эрчимжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны чиглэлээр гарч байгаа тушаал шийдвэр, албан бичгийг оновчтой тодорхойлох,
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах,
3. Төлөвлөгөөнд байгууллагын стратеги зорилгыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ, тухайн жилийн хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусган боловсруулах,
4. Хэрэгжилтийг тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан тайлагнах,
5. Хэрэгжилтийг тайлагнахдаа арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан тайлагнах,
6. Арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тодорхойлоходоо хэмжигдэхүйц тухай зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн уялдаа холбоотойгоор төлөвлөх,
7. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, хэрхэн зөв оновчтой төлөвлөх, тайлагнах талаар Захиргаа удирдлагын газраас сургалт хийж, заавар зөвлөгөө өгөх.